

Н.Батболд¹✉, С.Энхболд¹, Д.Мандах¹

¹ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Өвөр дэлгэр уулын монгол булшны судалгаа

Товчлол. “Монголын эзэнт гүрний язгууртан” захиалгат төслийн хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги 2020 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших Өвөр дэлгэр ууланд Монголын үед холбогдох 8 булш малтан судалж сумны зэв, төмөр хайч, төмөр илүүр зэрэг олдвор илрүүлснээс гадна булш тус бүрээс хүн, малын яс илэрч олджээ. Зохиогчид малын ясны судалгаанд тулгуурлан Монгол булшинд дагалдуулдаг шагайт чөмөгний учир холбогдлыг “ам барих ач” гэдэг хэлц үгтэй холбон тайлбарлах оролдлого хийсэн байна. Мөн энэ өгүүлэлд тухайн үеийн оршуулгын зан үйлд адууны ясаар тахил үйлдэж байсан талаар авч үзсэн байна.

Түлхүүр үг: Өвөр дэлгэр уул, Монгол булш, малтлага судалгаа, шагайт чөмөг, малын яс

N.Batbold¹✉, S.Enkhbold¹, D.Mandakh¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Research of Mongol graves in Uvur Delger Mountain

Summary. In 2020, as part of the custom project “Nobility of the Mongolian Empire”, the field research department of the Institute of Archeology of the MAS, in 2020, excavated 8 graves related to the Mongol period in Uvur Delger Mountain in the Sumber Sum area of Govsumber Province. Human and animal bones were found. Based on the study of animal bones, the authors tried to explain the meaning of the anklets found in Mongol graves in connection with the idiom “grandson to hold mouth”. Also, this article discusses the use of horse bones in the burial rituals of that time, and the fact that the practice of horse bones has been handed down since the Bronze Age.

Keywords: Uvur Delger Mountain, Mongol grave, excavation research, tibia, animal bones

Удиртгал

ШУА-ийн Археологийн хүрээлэн нь 2020 онд “Монголын эзэнт гүрний язгууртан” захиалгат төслийг хэрэгжүүлэн ажилласан. Тус төслийн хүрээнд Говьсүмбэр аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний анги Сүмбэр сумын нутаг Өвөр дэлгэр ууланд Монголын үед холбогдох 8 булш малтан судалжээ.

Тус судалгааны ангийн малтлага судалгаа хийсэн Өвөр дэлгэр уул нь Хэрлэн голоос урагш 50 км, Сүмбэр сумаас зүүн хойш 46 орчим км-т, Сансар уулаас хойш Малахын тал хүртэл үргэлжлэх оройгоороо хадтай намхан уулс толгодын хойд захад Малахын талын зүүн урд үзүүрт оршино. Энэхүү зүүнээс баруун тийш сунаж тогтсон намхавтар жижиг уулын өвөр бэлээр хиргисүүр, хүрлийн үеийн дөрвөлжин болон дугуй дараастай булш, Монголын үеийн зууван дугуй булш тархан байрлана. Энд нийт 90 дурсгал бүртгэн баримтжуулсны 45 нь монголын үеийн дугуй булш, бусад нь хиргисүүр, дөрвөлжин булш, хүрлийн үеийн дугуй чулуун овоолготой булш, түрэгийн тахилын онгон зэрэг дурсгал байлаа.

Анх энэхүү дурсгалт газрыг 2013 онд “Зүтгэлт гүн” ХХК-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны явцад илрүүлж судалгааны эргэлтэд оруулжээ [Батболд нар. 2013].

Малтан судалсан монгол булшнуудаас сумны зэв, төмөр хайч, төмөр илүүр зэрэг олдворуудаас гадна булш тус бүрээс хүн, малын яс илэрч олдсон байна. Малын ясны ихэнх нь адууны яс байсан бөгөөд энэхүү өгүүлэлд бид Монголын эзэнт гүрний үед холбогдох булш оршуулгаас илэрч олдсон адууны ясны судалгаа болон шагайт чөмөгний ясыг булшинд дагалдуулан тавих болсон учир холбогдлын талаарх өөрсдийн таамаглалыг дэвшүүлж байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Өвөр дэлгэр уулын монгол булшны малтлага, олдвор хэрэглэгдэхүүн, хүн малын яс зэрэг нь энэхүү өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болно. Монгол оронд малтан судалсан археологи, палеозоологийн судалгааны тайлан, хэрэглэгдэхүүнийг шүүж үзэхэд хүрэл зэвсгийн түрүү үеэс Монголын эзэнт гүрний үе хүртлэх дурсгалаас илэрсэн адууны ясны хэрэглэгдэхүүн арвин баялаг билээ. Гэвч эдгээрээс өдгөө бүрэн судлагдсан ясны хэрэглэгдэхүүн цөөн байдаг. Тэр дундаа монголын үед холбогдох булш оршуулгын дурсгалаас илэрсэн адууны ясны судалгаа байдаггүй байна.

Өвөр дэлгэрийн дурсгалт газар монголын эзэнт гүрний үед холбогдох найман (12, 13, 29, 30, 42, 43, 45, 49) дурсгал малтан судалсны долоон дурсгалаас малын яс их бага хэмжээгээр илэрч олдсон байна. Нийт 65 ширхэг малын яс илэрсэн бөгөөд үүний 45 ширхэг буюу 69.2 хувийг адууны яс эзэлж байна.

Эдгээр мал амьтны төрлийг тодорхойлохдоо ХААИС-ийн багш С.Андрейн “The comparative anatomy of the domestic animals” номыг ашигласан болно.

Булшны тодорхойлолт.

Булш 12. Өвөр дэлгэр уулын урд энгэрийн 2 бүлэг булшны зүүн талын бүлэг булшны зүүн хойд захад орших 3.6 x 4.5 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш (гар зураг 1). Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад бод малын ясны хугархай, үйрмэгүүд дараас чулууны төв хэсгээс цөөнгүй тоогоор гарч байсан. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсний дараа булшны хүрээ чулууг үлдээн бусдыг зайлуулахад жижиг нь 30 x 40 см, том нь 45 x 75 см хэмжээтэй 11 ш чулуугаар зууван дугуй хэлбэр гарган тойруулан өрсөн болох нь мэдэгдэв. Хүрээ чулууг авч булшны нүхний төвөөр малтлагыг үргэлжлүүлэхэд өнгөн хөрснөөс доош 35 см гүнээс 2 x 0.67 м хэмжээтэй хүрэн өнгийн хөрс зууван дугуй хэлбэртэйгээр ялгарч байв. Өнгөн хөрснөөс доош 80 см гүнд нүхний толгой болон цээжин хэсгээс гавлын яс, бугалга, шуу хавирга нуруу зэрэг яснууд эмх замбараагүй байдалтай олдсон бол хөлийн урт мөчний яснууд анатомийн байрлалаараа илэрч олдсон (гар зураг 2). Түүнчлэн зүүн хөлийн шилбэний хажуугаас 5 ширхэг зэв илэрч олдсон. Уг булш нь эрт цагт тоногдож анхны зохион байгуулалтаа ихэд алдсан байсан боловч хүний яс болон сумны зэв гарсан нь судалгааны өндөр ач холбогдолтой юм.

Булш 13. 3.5 x 4 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсний дараа булшны хүрээ чулууг үлдээн бусдыг зайлуулахад жижиг нь 30 x 46 см, том нь 52 x 70 см хэмжээтэй том жижиг нийлсэн 10 гаруй чулуугаар зууван дугуй хэлбэр гарган тойруулан өрсөн болох нь мэдэгдсэн (гар зураг 3). Харин хүрээ чулууны хойд, зүүн хойд талд байсан нэг, хоёр чулууг хөдөлгөсөн бололтой яг тэр хэсэгтээ онгойсон байлаа. Булшны нүхний төв хэсэгт малтлагыг үргэлжлүүлэхэд өнгөн хөрснөөс доош 25 см гүнд 2.2 x 0.81 м хэмжээтэй хүрэн өнгийн хөрс зууван дугуй хэлбэртэйгээр ялгарч байв. Өнгөн хөрснөөс доош 70 см гүнд булшны нүхнээс хүний гавлын яс, бугалга, шуу, хөлийн урт мөчний яснууд анатомийн байрлалаараа илэрч олдсон (гар зураг 4). Гавлын ясны баруун талаас төмрийн үлдэгдэл, зүүн талын хана орчмоос

босгож тавьсан бог малын шагайт чөмөгний хугархай, аарцагны зүүн талаас мөн төмрийн үлдэгдэл илэрч олдсон. Үүнээс өөр ямар нэгэн олдвор эд өлгийн зүйл илэрч олоогүй. Булшны нүхний гүн 97 см.

Були 29. Өвөр дэлгэр уулын урд энгэрт байрлах 2 бүлэг булшны баруун талын бүлэг булшны хамгийн зүүн хойд захын 5.1 x 4.8 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад бод малын ясны хугархай, үйрмэгүүд дараас чулууны төв хэсгээс цөөнгүй тоогоор гарч байлаа. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсний дараа булшны хүрээ чулууг үлдээн бусдыг зайлуулахад жижиг нь 65 x 45 см, том нь 55 x 110 см хэмжээтэй 16 ш чулуугаар зууван дугуй хэлбээр тойруулан өрсөн болох нь мэдэгдсэн (гар зураг 5). Уг хашлага чулуу нь 2.75 x 3.95 м хэмжээтэй байлаа. Уг булш бусад булшийг бодвол тонуулчдын гарт ихэд сүйдсэн байсан тул оршуулгын нүхний толбо мэдэгдэхгүй байсаар өнгөн хөрснөөс доош 50 см малгахад булшны нүх үл мэдэг ялгарч мэдэгдэв. Өнгөн хөрснөөс доош 90 см гүнд булшны нүхнээс зүүн хөлийн шилбэний яс анатомийн байрлалаараа илэрсэн бол бусад яснууд бүгд хөндөгдөж анхны байрлалаа алджээ. Гавлын зүүн талаас бог малын шагайт, булшны нүхний төвөөс маш муу хадгалалттай төмөр хайч илэрч олдсон (гар зураг 6). Гүн 114 см.

Були 30. 4.5 x 4 м голчтой зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэх явцад бод малын ясны жижиг хэлтэрхий хэсгүүд дараас чулуун дундаас илэрч олдож байв. Булшны хүрээ чулууг үлдээн цэвэрлэхэд жижиг нь 60 x 50 см, том нь 70 x 80 см хэмжээтэй 14 ш чулууг зууван дугуй хэлбээр тойруулан өрсөн болох нь мэдэгдсэн (гар зураг 7). Өнгөн хөрснөөс доош 25 см гүнд булшны нүхний толбо үл мэдэг ялгарав. 65 см гүнд булшны нүхнээс хүний урт мөчний яснууд анатомийн байрлалаараа илэрсэн бол бусад яснууд бүгд хөндөгдсөн байв (гар зураг 8). Нүхний төвөөс маш муу хадгалалттай төмөр хайч, зүүн хөлийн шилбэний дотор талаас хүрэл товруу, зүүн гарын шууны ясны хажуугаас төмөр илүүр, оршуулгын нүхний толгой талаас 3 ширхэг төмөр эдлэлийн үлдэгдэл зэрэг олдвор хэрэглэгдэхүүн илэрсэн.

Були 42. 4.6 x 3.8 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсний дараа булшны хүрээ чулууг үлдээн бусдыг зайлуулахад жижиг нь 30 x 10 см, том нь 45 x 80 см хэмжээтэй 16 ш чулуугаар зууван дугуй хэлбээр тойруулан өрсөн байсан (гар зураг 9). Уг хашлага чулуу нь 2.5 x 2.1 м хэмжээтэй байлаа. Өнгөн хөрснөөс доош 15 см гүнд хүний яснууд анатомийн байрлалаараа илэрч олдсон (гар зураг 10). Хүний ясны бүсэлхий

орчмоос тэгш өнцөгт хэлбэрийн төмөр эдлэлийн үлдэгдэл, гавлын ясны баруун талаас бог малын шагайт чөмөг, бог малын далны яс, гавлын ясны дагзанд наалдсан төмөр эдлэлийн үлдэгдэл зэрэг эд өлгийн зүйлс илэрч олдсон.

Були 43. 3.5 x 3.3 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэх явцад бод малын ясны жижиг хэлтэрхий хэсгүүд дараас чулуун дундаас илэрч олдож байсан. Энэхүү булшны дараас чулууны төвд дээрх булшнуудын адил зууван дугуй хэлбэрийн хашлага үйлдсэн байсан нь 2.2 x 2.7 м хэмжээтэй байв (гар зураг 11). Өнгөн хөрснөөс доош 25 см хүрэхэд оршуулгын нүхний толбо илэрсэн. 70 см гүнээс хүний урт мөчний яснууд анатомийн байрлалаараа илэрсэн бол цээжний яснууд эвдэгдэж байрлалаа алдсан байлаа. Гавлын ясны зүүн талаас үйсэн эдлэлийн үлдэгдэл (богтаг малгай), баруун шилбэний хажуугаас төмөр эдлэлийн үлдэгдэл, салтаан дундаас үйсэн эдлэлийн хэлтэрхий зэрэг олдвор эдлэлийн зүйлс илэрч олдсон (гар зураг 12).

Були 45. 4 x 3.5 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэх явцад бод малын ясны жижиг хэлтэрхий хэсгүүд дараас чулуун дундаас илэрч олдож байсан. Энэхүү булшны дараас чулууны төвд дээрх булшнуудын адил зууван дугуй хэлбэрийн хашлага үйлдсэн байсан нь 2.4 x 3.4 м хэмжээтэй байв (гар зураг 11). Өнгөн хөрснөөс доош 30 см гүнд 2.1 x 0.7 м хэмжээтэй хүрэн өнгийн оршуулгын нүхний толбо илэрсэн. 80 см гүнд хүний яснууд анатомийн байрлалаараа илэрч олдсон (гар зураг 13). Гавлын ясны баруун талаас төмөр эдлэлийн үлдэгдэл, зүүн талаас бог малын шагайт чөмөг, баруун мөрний орчмоос төмөр эдлэлийн үлдэгдэл, гавлын ясны хүзүү орчмоос товч хэлбэрийн тугалга зэрэг эд өлгийн зүйлс илэрч олдсон. Оршуулгын нүхний хэмжээ толгой талын өргөн 70 см, хөл талдаа 60 см, урт нь 2 м хэмжээтэй байна.

Були 49. 3.5 x 4 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэх явцад бод малын ясны жижиг хэлтэрхий хэсгүүд дараас чулуун дундаас илэрч олдож байсан. Энэхүү булшны дараас чулууны төвд дээрх булшнуудын адил зууван дугуй хэлбэрийн хашлага үйлдсэн байсан нь хойноос урагш 2.5 м, өргөн нь 1.5 м хэмжээтэй байв (гар зураг 14). Хашлага чулууны яг доороос буюу өнгөн хөрснөөс доош 20 см гүнээс хүний яснууд анатомийн байрлалаараа илэрсэн (гар зураг 15). Гавлын ясны зүүн талаас бог малын шагайт чөмөг, гавлын баруун талаас 2 ш сувс, хоёр хөлийн дундаас шатсан мод зэрэг олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсон.

Хэлэлцүүлэг

Монголын үеийн булшинд хэрэв эмэгтэй хүн оршуулсан бол төмөр хайч, хутга, хонины дал, шаант чөмөг, мөн ээмэг, бөгж, хүрэл толь зэргийг дагалдуулсан байдаг. Эрэгтэй хүнд бол төмөр хутга, модон аяга, мөнгө, зэс пял таваг, хонины шагай, хүүхдэд сумын төмөр зэв, мөн дал, шаант, заримдаа анч нохойг хамт оршуулсан, морь, эмээл, ялангуяа дөрөөг /ганц дөрөө/ дагалдуулсан байдаг юм. Ийм эд өлөг бүхий булшууд манай орны өнцөг булан бүрт малтан судлагдсан байдаг. Жишээлбэл: Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Их Богдын хормой, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Сүхбаатар аймгийн Мөнххааны Залаа, /Цагаан нуурын/ [Наваан 2018], Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уул [Амартүвшин нар 2015] зэрэг газруудыг дурдаж болно.

Өвөр дэлгэр ууланд малтан судалсан булшнууд бүгд эрт цагт тоногдсон байсан хэдий ч малтлага судалгааны үр дүнд 12 дугаартай булшнаас 5 ширхэг сумны зэв, 29, 30 дугаартай булшнаас төмөр хайч, 30 дугаартай булшнаас төмөр илүүр, хүрэл товруу зэрэг эд өлгийн зүйлс илэрч олдсоноос булш тус бүрээс хүн, малын яс илэрч олджээ. Эдгээр 8 булшны 4-өөс нь шагайт чөмөг илэрч олдсон байх ба нөгөө дөрөвт нь дагалдуулаагүй байна.

Монгол булшинд шагайт чөмөг дагалдуулдаг хойлгын зан үйл, учир холбогдлын талаар судлаачид өөрсдийн саналыг дэвшүүлсээр иржээ. Тухайлбал, доктор У.Эрдэнэбат дундад зууны нүүдэлчдийн булшинд шагай чөмөг дагалдуулан хийдэг нь талийгаач нөгөө ертөнцөд очоод хонь, ямаа, адуу, үхэр, тэмээн сүрэгтэй мөр бүтэн гэдэс цатгалан явахыг ерөөсөн бэлэгдлийн утгатай байсан бололтой [Эрдэнэбат 2010: 327] хэмээн үзсэн бол доктор Д.Эрдэнэбаатар шагайт чөмөг эрхэмлэх ёсны тухай монголчууд найр, наадам, айлчин гийчиндээ зориулсан зоог, тахилгын идээ, хурим, оршуулах зан үйлд шагай чөмөг байрлуулсан дэг ёс, бэлгэдэл цөм хүнд хандаж, амьдралын дундаршгүй ундарга болсон аж ахуйн гол үндэс болсон таван хошуу малын бэлгэдэл болно [Эрдэнэбаатар 1994: 94] гэжээ. Харин судлаач Р.Төрбат “Монголчууд нас барагчийг голдуу хойд зүгт хандуулан оршуулахдаа толгойн зүүн дээд талд шагайт чөмөг босоогоор тавьдаг. Энэ нь булшны нүхний зүүн хойд булан болно. Энэ зүг нь монгол бөөгийн “зүүдний зам, сүнс халих зам”-ын чигтэй тохирч байна. Монгол туулийн бэлгэдлийг нэгтгэн судалсан бүтээлээс үзэхэд, зүүн хойд зүгийг муу зүг хэмээн үзэж, Зүүн хойт тивийг эзлэн төрсөн Үхэр улаан мангас зүүн хойд тивийг эзлэнхэн төрсөн Шулмасын хаан гэх мэтийн хүн амьтанд хор хөнөөл учруулдаг махчин

мангас чухам энэ зүгт оршдог гэж дүрсэлдэг нь монголчуудын ертөнцийн төсөөлөлд харанхуй орон буюу нөгөө ертөнц нь хойд, зүүн зүгт оршдог ажээ. Ийнхүү шагайт чөмгийг булшны нүхний зүүн хойд буланд буюу сүнсний нөгөө ертөнцийн зүгт босоогоор тавьдаг нь уг заншил талийгчийн сүнсийг нөгөө ертөнцөд илгээх зан үйлтэй холбоотойг илтгэнэ” [Төрбат 2019: 36] хэмээн тус тус өгүүлсэн байдаг

Бид монгол булшинд шагайт чөмөг дагалдуулдаг зан үйлийг “ам барих ач” хэмээх хэлц үгтэй холбон тайлбарлаж өөрсдийн саналыг дэвшүүлж байна.

“Ам барих” гэдэг хэлц үгийг Монгол хэлний их тайлбар тольд “Аян замны явдал даахаа больсон хөгшин настандаа бяцхан хүүхдээр аманд нь сүүл үмхүүлэн эцсийн замд нь үдэх, хээр орхих, (“ам барих ачтай” – насан өндөр болоод үхэхийн цагт сүүл үмхүүлж амаа бариулан нүд аних ач хүүтэй гэсэн санаа) хэмээн тайлбарлажээ.

Мөн Л.Түдэв гуай “Шаант чөмгийг монголчууд заавал хальслан цэвэрлэж хальсыг нь галд өргөдөг. Хальстай нь идэхээс цэрвэдэг нэгэн хуучны ёсон буй. Тэр нь их дээр үеийн гарал үүсэлтэй юм. Өндөр насалсан хүн нүүдлийн ахуй амьдралд их дарамтлагдаж аян зам, нүүдлийн гар даахгүй байжээ. Тийм үед ураг төрлөөрөө цуглан цай будаалга хийж, нөгөөх хүндээ уураг сүүл томоохон хэрчмийг ач хүүгээр ам руу нь хийлгээд хойноос нь шаант чөмөгний шагайтай нарийн үзүүрээр түлхүүлдэг байжээ. Тийнхүү уураг сүүлэндээ хахаж нөгөөх өтгөс амьсгал хураадаг байж. Нэгэнт ам руу сүүл чихсэнээс өнгөрсөн юм болохоор амаа ангайсан чигтээ нүд аньдаг тул нөгөөх ач хүү амыг нь барьж хамхиж өгдөг байжээ. Үүнээс үүдэн “Ам барих ач хүүтэй боллоо” гэж настайчууд баярладаг тэр хачин үг гарчээ” [Түдэв 2000: 14] хэмээн “Аман хууль” номондоо тайлбарласан байдаг.

Энэ нь шагайт чөмөг ашиглан эцсийн замд нь үдсэн хүмүүсийн булшинд уг шагайт чөмгийг нь дагалдуулан оршуулдаг байсныг харуулж байна. Ингэхдээ хүний толгойн харалдаа ихэвчлэн зүүн хойд талд нь босоогоор нь тавьдаг нь судлаачдын үздэгээр бөө мөргөлийн муу зүгийн тэнгэр, эзэд ямагт зүүн хойд зүгт байрладагтай холбоотой байж болох юм. Мөн халх туульд зүүн хойд зүгийг “зүүдний зам, сүнс халих зам” хэмээн нэрийддэг [Дулам 2011, 135] тул шагайт чөмгөөр түлхүүлэн амьсгал хураасан хүн хэмээн муу зүгээс ирэх саад тотгороос хамгаалан хойд насны амьдралд нь хүлээлгэн өгч буй санаа байж магадгүй юм.

Өвөр дэлгэр уулын шагайт чөмөг дагалдуулсан булшны хүний ясанд хийсэн судалгаанаас үзэхэд нас харгалзахгүй (13-р булшинд 30-35 настай эмэгтэй, 42-р булшинд 60-65 настай эрэгтэй, 45-р булшинд 45-50 настай эрэгтэй, 49-р булшинд 15-

17 настай хүүхэд) дагалдуулсан байх бөгөөд энэ нь зөвхөн өндөр настай хүнд “ам барих ач” хэмээх хэлц үгийн дагуу үхэгсдийн зан үйл хийдэггүй байсныг харуулна. Учир нь өвчин зовлон, гэмтэл бэртэл хүнийг хөгшин, залуу гэж ялгагдаггүй тул ямар нэгэн байдлаар удаан хугацааны турш өөрөө бие даан явах чадваргүй болж нүүдлийн ая даахаа болсон тохиолдолд нас харгалзахгүй шагайт чөмөг ашиглан зан үйл гүйцэтгэдэг байсан байж магадгүй юм. Энэ нь мэдээж овог аймгийнхны нийтийн юм уу, гэр бүлийн эсвэл бөөгийн шийдвэрээр шийдэгддэг ёс байсан бололтой.

Харин зуурдаар юм уу гэнэтийн ослоор, дайн тулааны улмаас, нас өндөр болж ертөнцийн жамаар нас барсан хүмүүсийн булшинд шагайт чөмөг дагалдуулах шаардлагагүй байжээ хэмээн үзэж байна. Монгол улсын нутаг дэвсгэрт 2003 он хүртэл малтан шинжилсэн дундад эртний монголчуудад холбогдох 204 булшны 65%-д нь булшны нүх дотор босгож тавьсан богийн шагайт чөмөг тэмдэглэгдсэн [Эрдэнэбат нар. 2010] нь үүнийг батлах боломжтой юм.

Эртний нэгэн домог ёсоор бол “... Өглөг буяны эзэн Лхам бурхан цагаан сарын шинийн нэгний өглөө эрт айл болгонд ирж аз жаргал хүсэж хүн бүрт нэг нас нэмэх учиртай. Тэгтэл нэг удаа замд нь шулмасын элч таарч саатуулан хоргоожээ. Тэндээс арай ядан салаад явах гэтэл шуламын хүлгүүд Лхам бурханы хүлгийн хөлийг бэртээчихжээ. Энэ явдлаас хойш тэрхүү шулмын морьдын хөлийг хорьж байгаа нь энэ гэж “Шуламсын сүнс оршдог” шагайт чөмөг хугалдаг болсон гэдэг” [Мандах, Буян-Орших, 2020: 139]. Ийнхүү цагаан сараар хонины шагайт чөмөг хугалж битүү гаргадаг болсон нь маш эртний угшилтай нь тодорхой байна. Энэ нь ирж буй шинэ ондоо шагайт чөмөг ашиглан ямар нэгэн үхэгсдийн зан үйл хийлгүй элэг бүтэн байх болтугай хэмээн бэлэгдэж шагайт чөмөг хугалдаг эртний ёс байж болох юм. Харин Монголд буддын шашин дэлгэрч эхэлснээр үлгэр домогт Лхам бурхан зэрэг буддын шашны дүр түрэн орж ирсэн нь үхэгсдийн зан үйлд өөрчлөлт орсныг илтгэж байна.

Өвөр дэлгэр уулын монгол булшнаас илэрсэн малын яснаас хамгийн их буюу 69.2 хувийг адууны яс эзэлж байна. Хүн төрөлхтөн адууг гаршуулж гэжээж эхлэснээр алсын замыг товчлох унаа хөсөг болохын зэрэгцээ дайн байлдаанд хувьсал авч ирсэн. Орчин үеийн гэрийн гэжээвэр адууны үүлдэр, хамгийн эртний гэрийн адуу нь НТӨ 3500 жилийн өмнө Төв Азийн Ботайн соёлтой холбогдож байгаа нь археологийн дурсгалаар илэрч олдсон палеозоологийн олдвороор баталгаажсан хэмээн үзэж байгаа ч үүнийг хамгийн эртний адуу гэж үзэх хангалттай нотолгоо болж чадахгүй юм. Тиймээс орчин үеийн гэрийн адууны генетик болон газар

нутгийн асуудал тодорхой болоогүй байгаа юм. Ер нь оршуулгын зан үйлд адууны ясаар тахил үйлдэж, хойлгийн зан үйл хийх нь хүрэл зэвсгээс хойш уламжлагдан ирсэн байна. Гэхдээ хүрлийн үед Дорнод Монголын нутаг дэвсгэрт оршин суугчид нас барсан хүндээ морины толгой буюу адууны шүдийг эрхэм болгон дагалдуулдаг зан үйл нийтлэг байсан бөгөөд энэ зан үйл дараачийн үе бүр одоо хүртэл хэлбэр дүрс, агуулгаа өөрчлөн манай ард түмний зан үйлд уламжлагдаж ирсэн хэмээн үзэж болно.

Эрт үед хүн үхвэл морийг нь эмээл хазаартай нь хүүрийн дэргэд уях буюу алдаг байжээ. Монгол овогтон үхэгсэддээ морь хойлголох ёсны тухай монгол орноор зорчсон харийн элч нарын өгүүлснээс эш татахад “Их хааныг үхэхэд түүний хайртай сайн морьдыг алж, хамт оршуулна” [Плано Карпини 1988: 200] гэх буюу “язгууртан хүн аваас (үхвээс) түүний өмнө ширээ засаж тэвшинд мах, аяганд айраг хийж тавина. Мөн унагатай гүү, эмээл хазаартай морь хамт оршуулдаг. Бас адуу алж, арьсанд нь сүрэл чихэж, тавих бөгөөд махыг идэн ясыг шатаана” гэсэн байна. Эдгээр жишээ нь хэдийгээр сүүлийн үеийн зан үйл авч монголчуудын эртний дээд өвгөд үхэгсэддээ морь дагалдуулахын оронд дал, толгой, шүднээс оршуулгад оролцуулах заншил байснаас уламжлан дамжиж ирсэн гэж үзэх бүрэн үндэс байна. Монгол булшны судалгаанд язгууртны гэж үзэхүйц булш маш ховор тохиолддог. Энэ нь Монголчуудын тухайн үеийн ёс заншилтайгаа холбоотойгоор хаад, ихэс дээдсийнхээ нутаглуулсан газрыг, түүгээр ч зогсохгүй тухайн газрын нэрийг хүртэл нууцлаж байсан тухай сурвалж бичгүүдэд цөөнгүй тэмдэглэн үлдээсэн байдаг. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газарт орших монголын үеийн археологийн бүлэг дурсгалын 5-р булшнаас зохион байгуулалт нь алдагдаагүй бүтэн адууны араг яс, амгай, зуузай, хазаарын чимэг, эмээл, дөрөөтэйгээ гарч ирсэн байна. Өвөр дэлгэрийн монгол булшнуудад үүнтэй ижил зан үйл харагдаж байгаа бөгөөд эдгээр дурсгал нь зүгээр нэг жирийн иргэдийн оршуулга бус алтан ураг, боржигончуудын холбоо хамаарал бүхий газар байсныг үгүйсгэхгүй. Харин монгол булшийг малтан судалсан эрдэмтдийн судалгаанаас үзэхэд монголын жирийн иргэдийн булш нь гол төлөв бог малын яс (богийн шаант чөмөг, шагай, бусад яс, цөөн тохиолдолд бодын яс), дагалдуулсан байдаг бөгөөд Өвөр дэлгэрийн дурсгалт газрынх шиг малтсан дурсгал бүрээс малын яс илэрсэн тохиолдол тэмдэглэгдээгүй байна.

Дүгнэлт

Өвөр дэлгэр уулын булшнууд нь намхан дугуй чулуун дараастай гадаад зохион байгуулалт болон оршуулгын зан үйл, дагалдуулсан эд өлгийн зүйлс зэргээрээ Монголын үеийн булш гэдэг нь тодорхой юм. Оршуулгын нүх гүн биш 0,25-1,18 м, банзан авсгүй, ихэвчлэн чулуун хашлаганд нас барагчаа оршоосон байв. Мөн монгол булшны оршуулгын зан үйлийн нийтлэг шинж болох нүхний баруун болон зүүн дээд буланд шагайт чөмөг босгон тавьсан, нас барагчийн нуруун дор богийн нурууны яс хийсэн байлаа.

Олдвор хэрэглэгдэхүүний хувьд монгол булшнаас нийтлэг илэрдэг сумны зэв, үйлийн хайч, илүүр, хутга зэргээс гадна дугуй хэлбэрийн голдоо дөрвөлжин нүхтэй, нүхний дөрвөн талд “大元通宝” (Da yuan tong bao) хэмээн ханзаар бичсэн хүрэл зоос олдсон юм. Энэхүү зоосыг Юань улсын Их хаан Хайсан Хүлэгийн 2-р он буюу 1309 онд гүйлгээнд гаргаж байжээ.

Өвөр дэлгэр уулын булшны ерөнхий гадаад байгууламж, оршуулгын зан үйл, олдвор хэрэглэгдэхүүн, хойлгын малын яс зэргээр XIII-XIV зууны үед хамааруулан үзэж болохоор байна.

Судлаачид булшинд шагайт чөмөг дагуулан тавих ёс заншил түрэгийн соёлын хүрээнд НТ VIII зууны үе гэхэд хэлбэршин тогтож улмаар зүүн зүг түгэн дэлгэрсэн бөгөөд хожим нь нийт монгол угсаатны оршуулгын зан үйлийн нэгэн онцлог болтлоо хөгжсөн [Батсайхан 2022: 522] хэмээн үздэг байна. Энэ нь эртний нүүдэлчдийн дунд шагайт чөмөг ашиглан үхэгсдийн зан үйл хийх ёс эрт үеэс хэлбэршин тогтож булшинд шагайт чөмөг дагалдуулах нь зан үйл үйлдсэн эсэхээс хамаарахгүй нас барсан хүн болгонд дагалдуулдаг нийтлэг зан үйл болон тогтсон байж магадгүй юм. Улмаар буддын шашин Монголд дэлгэрч эхэлснээр уг ёс халагдан оршуулгын зан үйлд өөрчлөлт орсон хэмээн үзэж байна.

Талархал

“Монголын эзэнт гүрний язгууртан” захиалгат төслийг хэрэгжүүлэхэд тусалж дэмжин хамтран ажилласан Говьсүмбэр аймгийн “Боржигон өв” музейн захирал А.Ундармаа, эрдэм шинжилгээний ажилтан Б.Лхагвамаа, бүртгэл мэдээллийн санч Б.Чойдаш, тайлбарлагч Г.Ариунтунгалаг нарт талархал илэрхийлье.

Ном зүй

Амартүвшин нар. 2015 – Амартүвшин Ч, Батболд Н, Эрэгзэн Г, Батдалай Б. Чандмань Хар уулын археологийн дурсгал I, УБ, 2015. Тал. 196-313.

Андрей 1997 – Андрей С. The comparative anatomy of the domestic animals. Iowa state University

library, 1997.

Базарсүрэн 2021 – Базарсүрэн Ж. Чингис хааны цэрэг, дайтах ухаан, зэр зэвсэг. УБ, 2021. Тал. 215 – 217.

Батболд нар. 2013 – Батболд Н., Ишцэрэн Л., Галдан Г. Говьсүмбэраймгийн Сүмбэр сумын нутаг дахь “Зүтгэлт гүн” ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын 13077Х тусгай зөвшөөрөлтэй талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. УБ, 2013.

Батсайхан 2022 – Батсайхан З., Төрбат Ц. Эртний монголчуудын археологийн дурсгалыг судлах асуудалд (МЭ VIII-XV зуун). – З.Батсайхан. Хүннүгийн түүх, археологийн судлал. МУИС, профессорын эрдмийн өв. Бүтээл туурвилын эмхэтгэл. УБ, 2022. Тал. 518-522.

Дулам 2011 – Дулам С. Монгол бэлэгдэл зүй II. Өнгөний бэлэгдэл зүй, зүг чигийн бэлэгдэл зүй. УБ, 2011.

Мандах, Буян-Орших 2020 – Мандах Д., Буян-Орших Б. Чандмань хар уулын монгол булшинд дагалдуулсан шагайт чөмөгний судалгаа. – Чандмань хар уулын археологийн дурсгал II. УБ, 2020., Тал. 129-140.

Наваан 2018 – Наваан Д. Дорнод Монголын хүрлийн үе. – Нэгэн сэдэвт зохиол, гарын авлага, товхимол. МУИС-ийн Бүтээл туурвилын эмхэтгэл I боть. УБ, Тал. 115.

Плано Карпини 1988 – Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. УБ, 1988., Тал. 9-93.

Төрбат 2019 – Төрбат Р. Монголчуудын шагайт чөмөг эрхэмлэх зан үйлийн тухай. – Acta Historica. Tom. XX, Fasc. 3. УБ, 2019.

Түдэв 2000 – Түдэв Л. Аман хууль. УБ, 2000, Тал. 14.

Эрдэнэбаатар 1994 – Эрдэнэбаатар Д. Монголчуудын шагайт чөмөг эрхэмлэх ёсны тухай (VII-XIV зуун) – Түүхийн судлал Tom. XX-VII-XXVIII, Fasc. 10. УБ.

Эрдэнэбат 2010 – Эрдэнэбат У. Монгол булшны судалгаа. – Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу. УБ, 2010, Тал. 313-378.

Эрдэнэ-Очир, Худяков 2016 – Эрдэнэ-Очир., Э., Худяков Ю.С. Монгол эртний нүүдэлчдийн зэр зэвсэг. – “Монголын археологийн шинэ судалгаа” цуврал II. УБ, 2016.



Эрэгзэн нар. 2020 – Эрэгзэн Г., Цогтбаатар Б., Батболд Н., Болдхуяг Д., Базаргүр Д., Батболд Г., Энхболд С., Мандах Д., Эрдэнэ Б. “Монголын эзэнт гүрний язгууртан” захиалгат төслийн хайгуул, малтлага судалгааны тайлан. УБ, 2020.

唐石父 2001 – 唐石父. 中国古代钱币. 上海古籍出版社., 2001年. 283 页.






Хүснэгт 1. Малтан судалсан дурсгалын товч мэдээлэл


№	Дурсгалын дугаар	Дараас чулууны хэмжээ (м)	Гүн (м)	Оршуулгын нүхний чиглэл	Хүний яс	Олдвор
1.	Булш 12	3.6 x 4.5	1.18	Чанх хойш	50 – 55 настай эрэгтэй	5 ширхэг төмөр зэв
2.	Булш 13	3.5 x 4	0.97	Баруун хойш	30 – 35 настай эмэгтэй	Бог малын шагайт чөмөг, төмрийн үлдэгдэл
3.	Булш 29	5.1 x 4.8	1.14	Чанх хойш	70 + настай эмэгтэй	Төмөр хайч
4.	Булш 30	4.5 x 4	0.8	Чанх хойш	25 – 30 настай эмэгтэй	Төмөр хайч, хүрэл товруу, төмөр илүүр, 3 ширхэг төмөр эдлэлийн үлдэгдэл
5.	Булш 42	4.6 x 3.8	0.25	Чанх хойш	60 – 65 настай эрэгтэй	Тэгш өнцөгт хэлбэрийн төмөр эдлэлийн үлдэгдэл, Бог малын шагайт чөмөг, бог малын далны яс Төмөр эдлэлийн үлдэгдэл
6.	Булш 43	3.5 x 3.3	1.0	Чанх хойш	25 – 30 настай эмэгтэй	Үйсэн эдлэлийн үлдэгдэл (богтог малгай), Төмөр эдлэлийн үлдэгдэл,
7.	Булш 45	4 x 3.5	1.0	Чанх хойш	45 – 50 настай эмэгтэй	Төмөр эдлэлийн үлдэгдэл, Бог малын шагайт чөмөг, Товч хэлбэрийн тугалга
8.	Булш 49	3.5 x 4	0.30	Баруун хойш	15 – 17 настай хүүхэд	Бог малын шагайт чөмөг, 2 ш сувс

Хүснэгт 2. Олдворын тодорхойлолт


Олдворын нэр	Дурсгалын дугаар	Хэмжээ	Тодорхойлолт	Гар зураг
Төмөр зэв 5 ш	Булш 12	Урт – 10.8 см Өргөн – 2.4 см Зузаан – 0.25 см	Цавчуур зэв. Энэхүү зэв сурвалжтай төмөр зэвний бүлэгт багтах ба трапец хэлбэрийн хавтгай зэв ажээ. Уг зэвний үүрэг зориулалт нь хуяг хамгаалалтгүй үед болон морийг харваж шархдуулах зориулалттайгаас гадна ан авд хэрэглэдэг байсан бололтой (Сэргээн засварлалт хийгдсэн).	
		Урт – 14 см Өргөн – 2.2 см Зузаан – 0.4 см	Хануур зэв. Энэхүү зэв нь сурвалжтай төмөр зэвний бүлэгт багтах ба цүүц хэлбэрийн хавтгай зэв ажээ. Уг зэв нь хуяг нэвтрэх, гүн шарх үүсгэх зориулалттай бололтой (Сэргээн засварлалт хийгдсэн).	

		<p>Урт – 10 см</p> <p>Өргөн – 3 см</p> <p>Зузаан – 0.2 см</p>	<p>Барс саалины гилбэр.</p> <p>Энэхүү зэв нь сурвалжтай төмөр зэвний бүлэгт багтах ба хоёр талдаа сэрвээтэй нимгэн хатгай зэв ажээ. Уг зэв нь хуяг нэвтрэх, том талбайгаар гүн шарх үүсгэх, зоогдсон үед хоёр талын сэрвээ тээглэх зориулалттай бололтой (Сэргээн засварлалт хийгдсэн).</p>	
		<p>Урт – 13 см</p> <p>Өргөн – 3.4 см</p> <p>Зузаан – 0.2 см</p>	<p>Хануур зэв.</p> <p>Энэхүү зэв нь сурвалжтай төмөр зэвний бүлэгт багтах ба үзүүр охор, хүзүү урт хавтгай зэв ажээ. Уг зэв нь хуяг нэвтрэх, гүн шарх үүсгэх зориулалттай бололтой (Сэргээн засварлалт хийгдсэн).</p>	
		<p>Урт – 13 см</p> <p>Өргөн – 2 см</p> <p>Зузаан – 0.4 см</p>	<p>Хануур зэв.</p> <p>Энэхүү зэв нь сурвалжтай төмөр зэвний бүлэгт багтах ба үзүүр охор, хүзүү урт хавтгай зэв ажээ. Уг зэв нь хуяг нэвтрэх, гүн шарх үүсгэх зориулалттай бололтой (Сэргээн засварлалт хийгдсэн).</p>	
Хүрэл гархи	Булш 29	2.2 x 2	<p>Хэвэнд цугтан хийсэн хүрэл гархи. Уг эдлэлийн нэг талд ховил гаргасан нь өөр зүйлийг холбон бэхлэхэд зориулагдсан бололтой.</p>	
Төмөр хайч	Булш 30	<p>Урт – 20 см,</p> <p>баруулын өргөн 9 см,</p> <p>зузаан – 0,5 см.</p>	<p>Хооронд нь нугаслан холбосон хоёр гуя нарийн төмөр ир гаргаж цагариг мэт бариул гарган хийсэн үйлийн хайч. Нэлээд зэвэрч муудсан ч харьцангуй бүтэн байна. Сэргээн засварлалт хийгдсэн.</p>	
Төмөр хайч	Булш 30	<p>Их биеийн урт – 18 см,</p> <p>баруулын өргөн 8 см,</p> <p>зузаан – 0,5 см.</p>	<p>Хооронд нь нугаслан холбосон хоёр гуя нарийн төмөр ир гаргаж цагариг мэт бариул гарган хийсэн үйлийн хайч. Нэлээд зэвэрч муудан хэд хэдэн хэсэгт хуваагдсан. Сэргээн засварлалт хийгдсэн.</p>	
Төмөр хутга	Булш 30	<p>Урт – 23,5 см,</p> <p>Өргөн – 2,2 – 4,4 см,</p> <p>Зузаан 1 см</p>	<p>Төмөр хутга.</p> <p>Зэвэнд идэгдэж, олон хэсэг болон хугарсан төмөр хутганы үлдэгдэл. Балтаг хэсгийн өргөн их бие болон ишний хэсгээс харьцангуй өргөн 4,4 см, балтагнаас хойш ишрүүгээ нарийссан байна.</p>	


Төмөр эдлэл	Булш 30		Төмөр эдлэл. Нарийн хавтгай төмрийн нэг талын үзүүрийг нугалж, эсрэг талын үзүүрийг мурийлган дэгээ гарган тэрхүү дэгээ мэт хэсгээрээ 2 төмрийг амгайвчлан холбожээ. Хоёр талын төмөр тус бүрт нэг нэг нарийн хавтгай төмрийг дөрвөлжлөн бэхэлгээ маягаар бөгжилсөн байна. Үндсэн үүрэг зориулалт тодорхойгүй боловч малтлагын явцад дээрх төмөр эдлэлтэй барьцалдсан моднууд илэрсэн боловч хадгалалт муу байсны улмаас үйрч унасан.	
Зоос	Булш 30		Дугуй хэлбэрийн голдоо дөрвөлжин нүхтэй, нүхний дөрвөн талд “大元通宝” Da yuan tong bao хэмээн ханзаар бичсэн хүрэл зоос. Энэхүү зоосыг Юань улсын Их хаан Хайсан Хүлэгийн 2-р он буюу 1309 онд гүйлгээнд гаргаж байжээ.	
Хүрэл эдлэл	Булш 30	Голч – 4.8 см	Нүүрэн талыг нарийн үзүүртэй зүйлээр сараачин сийлсэн, голдоо бэхэлж тогтоох зориулалтаар 2 мм орчим голчтой нүхэлсэн дугуй хүрэл эдлэл.	
Илүүр	Булш 42	20.1 x 4.2 см	Хоёр хэсэг болон хуваагдсан төмөр илүүр.	
Сувс	Булш 49	1.1 x 0.4 см 0.5 x 0.6 см	Хөх өнгийн болон шаргал өнгийн сувс. Эхний буюу хөх өнгийн сувс нь тэгш бус хэмтэй ороомог маягийн хээтэй гонзгой хэлбэртэй голдоо нэвт гаргасан нүхтэй. Удаах буюу шаргал өнгийн сувс нь цагариг хэлбэртэй байна.	




Гар зураг 1. 12-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг




Гар зураг 2. 12-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал




Гар зураг 3. 13-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг




Гар зураг 4. 13-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал




Гар зураг 5. 29-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг




Гар зураг 6. 29-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал




Гар зураг 7. 30-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг




Гар зураг 8. 30-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал




Гар зураг 9. 42-р булины дэвсгэр зураг




Гар зураг 10. 42-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал




Гар зураг 11. 43, 45-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг




Гар зураг 12. 43-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал



Гар зураг 13. 45-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал



















Гар зураг 14. 49-р булины дэвсгэр зураг



Гар зураг 15. 49-р булины хүрээ чулуу, оршуулга илэрсэн байдал

Хүснэгт 3. Өвөр дэлгэр уулын монгол булшны малтлагаас илэрсэн адууны яс

	<p>Equus skeletal anatomy</p>  <p>■ Булшнаас гарсан яс</p>
<p>Були-12</p>	
	<p>Equus skeletal anatomy</p>  <p>■ Булшнаас гарсан яс</p>
<p>Були-13</p>	
	<p>Ovis skeletal anatomy</p>  <p>■ Булшнаас гарсан малын яс</p>
<p>Були-29</p>	
	<p>Equus skeletal anatomy</p>  <p>■ Булшнаас гарсан яс</p>

	<p>Ovis skeletal anatomy</p>  <p>■ Бушнаас гарсан малын яс</p>
<p>Були-42</p>	
	<p>Equus skeletal anatomy</p>  <p>■ Булнаас гарсан яс</p>
<p>Були-43</p>	
	<p>Ovis skeletal anatomy</p>  <p>■ Бушнаас гарсан яс</p>
<p>Були-45</p>	
	<p>Equus skeletal anatomy</p>  <p>■ Булнаас гарсан яс</p>
<p>Були-49</p>	

Л.Мөнхбаяр¹✉, Б.Бат-Эрдэнэ², Г.Батболд¹

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн. Монгол улс, Улаанбаатар-13330,

Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

² Өвөрхангай аймгийн музей. Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум

Монголын эзэнт гүрэн болон Мин улсын үед холбогдох хоёр хүрэл тамга

Товчлол. Өвөрхангай аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй хоёр хүрэл тамганы он цагийг нарийвчлан тогтоож, судалгааны эргэлтэд оруулахыг зорилоо. Тус тамганууд дээр буй нангиад бичээсний уншлагаас үзвэл энэхүү тамганууд Монголын эзэнт гүрний хийгээд түүний дараахан үеийн монголын түүхийн чухал баримт болох нь тодорхой болов.

Түлхүүр үг: Хүрэл тамга, Юань гүрэн, Давааны арын муж, Линбэй, Мин улс, Шин жоу

L.Munkhbayar¹✉, B.Bat-Erdene², G.Batbold¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1.

Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

²Museum of Uvurkhangai province. Arvaikheer soum,

Uvurkhangai province, Mongolia

Two bronze seals related to the Mongolian Empire and Ming dynasty

Summary. The purpose is to determine the exact dates of the two bronze seals kept in the museum fund of Uvurkhangai aimag and to consist of them into our research. On or after reading the Chinese inscriptions on these two seals, it became clear that these seals were important documents in the history of Mongolia during the Mongol Empire and its aftermath, also, especially during the Ming Dynasty. The first seal dated the first year of Huang-ch'ing 皇慶 [1312] remains the administrative official seal of the Judicial proceeding office one of the special units of Ling-bei Province during the Yuan Dynasty, (the administrative and governments unit occupied approximately the area of present-day Mongolia), was it first found and identified in Mongolia. The second seal dated the first year of Yong-Le [1403] an army seal of the header of the centurion family “Xing zhou” one of the special military organizations during the early Ming dynasty.

Keywords: Bronze Seals, Yuan Dynasty, Ling-bei Province, Ming Dynasty, Xing zhou

Удиртгал

Дундад зууны үед холбогдох олон дурсгал Монгол нутгаас ихээхэн хэмжээгээр олддог бөгөөд түүний дотроос бичиг үсгийн холбогдолт олдвор багагүй тоотой олдож байна. Тэр дундаа төр ёсны уламжлалтай холбоо бүхий тамга тэмдгийн зүйл олдож буй нь монголын дундад зууны үеийн түүхийг тодруулах томоохон баримт болох юм.

Өгүүлэлд хамрагдсан тус хоёр тамга одоо Өвөрхангай аймгийн музейд хадгалагдаж буй бөгөөд тус музейн эрдэм шинжилгээний ажилтнууд Юань гүрэн, Мин улсын үед хамрагдана хэмээн зураг тайлбарын хамт нийтлүүлж байжээ [Бат-Эрдэнэ 2012: 30-31].

Юань гүрний үеийн тамгыг хаанаас олдсон талаар музейн баримт бичигт: “Б.Ринчен, Д.Пэрлээ нар Баруунбаян-Улаан, Богд сумын зааг Юань гүрний үеийн хот болох Шаазан толгой гэдэг газраас олж илрүүлж музейд хадгалуулсан байна” гэжээ [Бат-Эрдэнэ 2012: 30-31]. Д.Пэрлээ ...Тус тамга олдсон нутгаас (Өвөрхангай Богд сумаас) бас хүрэл тамга хоёр олддоод, 1 нь, Өвөрхангайн төв Арвайхээр хотын музейд, нөгөө нь Богд сумын орон нутаг судлах кабинетэд бий. Одоогоор шинжлэгчдийн мэдэлд ирээгүй боловч нэг нь Юань улсын үед холбогдох нь мэдэгдсэнийг ташрамд тэмдэглэе [Пэрлээ 2001: 105-106] хэмээсэн байна. Тус тамга нь “Шаазан толгой”-гоос олдсон гэх боловч хэзээ олдсон нь тодорхойгүй байна.

Нэгдүгээр тамга

Тамганы тодорхойлолт:

Энэхүү тамга нь дөрвөлжин ултай, өндөр 8,7 см, улны хэмжээ 7,6 х 7,7 см, зузаан нь 2,2 см. Тамганы бариул нь гонзгой дөрвөлжин хэлбэртэй дээшээ нарийссан [Бат-Эрдэнэ 2012: 30-31].

Тамгыг хүрлээр цутгаж хийсэн бөгөөд тамганы дардас нь дөрвөн эгнээ дөрвөлжин үсгээр бичсэн байна. Тамганы бариулын хоёр талд Нангиад бичгээр бичсэн бичээстэй.

Уг тамга бүхий л талаасаа элэгдэж, зарим газраа эмтэрсэн, ул талдаа дөрвөлжин үсэг нь гол хэсэгтээ үрэгдэж бага зэрэг тодорхой бус болсон байна.

Нангиад бичээс

Тус тамганы ар талд нийт 4 мөр нангиад бичээс байгаа бөгөөд тамганы бариулын баруун хэсэгт 2 мөр үүнээс, I мөрөнд 11 үсэг, II мөрөнд 1 үсэг, зүүн хэсэгт 2 мөр үүнээс, III мөрөнд 5 үсэг, IV мөрөнд 7 үсэг байна.

Тус бичээсийг баруун талаас буюу хэнд хамаарах талаас нь дугаарлан уншив.

I – 嶺北等處行中書省理問所印-lǐng běi děng chù xíng zhōng shū shěng lǐ wèn suǒ

II – 印- yìn

III – 中書禮部 造-zhōng shū lǐbù zào
IV – 皇慶元年三月 日-huáng qǐng yuán nián sān yuè rì

Тамганы нангиад бичээсний орчуулга:

I – Линбэй (Давааны ар муж) дахь төвлөн засах төлөөний яамны[газрын] шүүн таслах газрын

II – тамга

III – Төвлөн засах [яамны] Ёслолын яам үйлдэв

IV – Хуан Чингийн тэргүүн оны 3-р сар өдөр гэсэн утгатай болж байна.

Хуан чингийн тэргүүн он бол Аюурбарбад буюу Буянт хааны тэргүүн он (1312) болно.

Тамга олгосон газар бол Төвлөн засах Ёслолын яамнаас олгосон бөгөөд Юань улсын үеийн бүх тамгыг яамнаас эрхлэн олгож байжээ. Тус яаманд тамга үйлдэх алба (The seal manufacturing office-8A - 鑄印局 [Farquhar 1990: 196]) байх бөгөөд уг алба бүхий л албан тамгыг цутгах, бичиглэх-сийлэх үйлийг эрхэлж байжээ. Тус алба 1268 он байгуулагдсан байна.

Тухайн тамгыг эзэмшигчийн тухай хэлбэл Линбэй буюу Давааны ар мужийн шүүн таслах газрын тамга болох бөгөөд Линбэй муж нь Юань улсын судрын 58-р бүлэгт дурдсанаар ... 皇慶元年, 改嶺北等處行中書省, 改和林路總管府爲和寧路總管府 [元史 1976: 1383]. ... Хуан-чингийн тэргүүн онд Давааны Ар зэрэг газрын (Линбэй дэнчу) нутгийн төвлөн засах яам гҮж халжээ. Хө лин (Хархорум) замын нийтийн даргын тойргийг Хө нин (Хөнин) замын нийтийн даргын тойрог болгожээ... ...In the first year of Huang-ch'ing 皇慶 [1312] it was changed to the hsing-chung-shu-sheng of places such as Ling-pei and the Ho-lin (Qorum) lu tsung-kuan-ju was changed to the Ho-ning-lu-tsung-kuan-fu [Cleaves 1952: 26] ... хэмээн тэмдэглэсэн бөгөөд тус тамга нь уг түүхэн өөрчлөлт болсон жил нь тус албаны тамгануудыг сольсон болохыг археологийн баримтаар баталж буй чухал олдвор болох юм.

Линбэй дахь төвлөн засах төлөөний яамны [газрын] шүүх таслах газарт: д. Албан хаагч: шүүн таслагч түшмэл-4А- (ливэн lǐ wèn 理問) хоёр, -5В-туслагч шүүгч (фу ливэн lǐ wèn 副理問) хоёр. Үйлчлэх албанд: бичиг хэргийн эрхлэгч-нэг, бичиг хэргийн ажилтан-нэг[Farquhar 1990: 397] тус тус байжээ.

Дөрвөлжин бичиг

Тамганы ул хэсэгт буй үндсэн бичээс дөрвөлжин үсгээр, нангиад хэлээр үйлдсэн байна. Нийт дөрвөн мөр бөгөөд дээр дурдсанчлан голын хэдэн үсэг үрэлтийн улмаар уншигдахад бага зэрэг хүндрэлтэй байсан боловч ар шилэнд буй хятад үсгийн сэргээлтээр харьцуулалт хийж уншиж гүйцэв.

Дөрвөлжин үсгээр бичсэн үгсийн уншлага:

1. liq bei deq

2. c'ü qin [c]in
3. seu seŋ li
4. wen su yin

Хоёрдугаар тамга

Тамганы тодорхойлолт:

Тамга нь 8.6 см өндөр, дөрвөлжин ултай, улны хэмжээ 7.1x7.1 см, зузаан нь 1.4 см, 845 гр. Тамганы бариул нь зуван гонзгой хэлбэртэй дээшээ нарийссан. Тамга нь бариулын хоёр талд гурван мөр, улны нэг хажууд нэг мөр хятад бичээстэй. Дардас нь дөрвөн эгнээ эвхмэл ханз үсгээр бичсэн. Их бие дээрх бичээсний агуулга нь Мин улсын 3 дугаар хаан Ён Дүгийн цэргийн зуутын даргын тамга гэсэн утгатай. Дээрх тамганы адил дардас болон их бие дээрх бичээснүүд нь нарийн судалж шинжлэгдээгүй. Мин улсын тамга нь олдсон газар болон хэзээ олдсон тодорхойгүй [Бат-Эрдэнэ 2012: 30-31] хэмээн өмнөх судалгаанд дурджээ.

Уг тамга нь хадгалалт сайн боловч тамганы хажуу талын бичээсний сүүлийн хоёр үсгийн орчимд хурц зүйлээр үрж үзсэн байна. Тиймээс сүүлийн хоёр утга үсгийг дардас дээр буй “Шин [жоу]-гийн нэг зуун гуч дугаар” хэмээх үг байх бөгөөд зуутын ноёдын хэд дэх зуутын даргын тамга болох дэс дугаар байна.

Харин бидний шинэ уншлагаар тамганы нангиад бичээсийг сэргээн уншвал

Ар талын бичээс:

Зүүн 1 - 永乐元年八月 日 - yong le yuan nian ba yue ri

Зүүн 2 - 禮部造 - li bu zao

Баруун 1 - 兴州中屯衛中千戶所百戶印 - xing zhou zhong tun wei zhong zhong qian hu suo bai hu yin

Тамганы бичээсний орчуулга:

Зүүн 1 - Юн Ли-гийн тэргүүн он (1403) он 8-р сар өдөр

Зүүн-2 Ёслолын хэлтэст үйлдэв

Баруун 1 - Шин жоу-гийн Дунд [тойрог] Харуулын дунд мянганы зуутын (өрхийн) тамга

Дардасны бичээс:

1. 兴州中屯-xing zhou zhong tun

2. 衛中中-wei zhong zhong

3. 千戶所-qian hu suo

4. 百戶印-bai hu yin

Хажуу талд:

兴字一百三十...号- xing zi yi bai san shi ...hao

Тухайн тамгыг эзэмшигчийн хувьд Тамганы бичээсний утга нь (Шин Жоу-гийн Жун Түн-гийн харуулын Дунд Мянганы газар дахь Зуутын тамга). Шин жоу-гийн Дунд Харуулын газар гэдэг нь Мингийн Юн Ли-гийн анхдугаар оны 2 сард буюу 1403 онд байгуулагдсан харуулын алба юм [张廷玉 1995].

Тус жоу-гийн газар нутаг нь өнөөгийн БНХАУ-ын Хэбэй мужийн нутаг буюу Цагаан хэрмийн ар бүс нутаг юм. Тус онд өмнө байсан харуулын албыг шинэчлэн өргөтгөж Шин жоу-гийн Зүүн, Баруун, Дунд, Өмнөд, Хойд хэмээх таван газар болгон зохион байгуулсан байна. Тус тамганы бичээснээс харахад 1403 онд ахин шинэчлэн байгуулж...兴州左屯卫洪武中, 兴州右屯卫洪武中, 兴州中屯卫洪武中, 兴州前屯卫洪武中, 兴州后屯卫洪武中.

Шин жоу нь Умардын цэргийн бүгдийг захирагчийн газарт (后军都督府) харьяалагддаг байжээ. Уг Шин жоугийн суурийг анх 1371 онд Хун Ү- 4 онд Умардаас сэргийлэх зорилгоор Цагаан хэрмийн хойгуур иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажил эхэлсэн байдаг. Энэ нь Умардаас хамгаалах дүси-г байгуулж эхэлсэн бөгөөд 1391 он гэхэд өнөөгийн Си Чуанаас Ляодунгийн хойг хүртэл нутгуудад иргэдийг суулган хот барих, тариалан эрхлэх ажил эхлүүлсэн байдаг [韦占彬 2001:29-31]. 1371 оны 3 сард Шин жоу-гийн нутагт 17000 өрхийг нүүлгэн шилжүүлснээр эхлэлтэй юм.

Мин ши-гийн Шү Да-гийн намтарт Умардыг түвшитгэх цэрэг, агт сургах, хот засах харуулын газрыг байгуулж нийт 254 нэгжид хуваасан байна. “Нүүлгэсэн өрх 35800 нийт 197000 хүнийг харуулын сууринуудад тараан суулгаж цэргийн хүнс бэлтгэхээр газар тариалан эрхлүүлэв” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Дүгнэлт

Юань улсын үед хамаарагдах буюу нэгдүгээр тамга нь Давааны ар муж /Линбэй/ дахь төвлөн засах төлөөний яамны [газрын] шүүх таслах газрын тамга болох бөгөөд он цагийн хувьд Хуан чингийн тэргүүн он нь Аюурбарбад буюу Буянт хааны тэргүүн он (1312) болно. Тамга олгосон газар нь Төвлөн засах Ёслолын яамнаас олгосон бөгөөд Юань улсын үеийн бүх тамгыг яамнаас эрхлэн олгож байжээ.

Тус тамга нь уг Хө лин зам /чөлгө/-ын нэрийн сольж түүхэн өөрчлөлт болсон жил нь тус албаны тамгануудыг сольсон болохыг мөн Давааны арын муж буюу Хархорумд төвлөсөн Юань улсын засаг захиргааны нэгжүүдийн талаарх түүхэн мэдээ баримтыг археологийн баримтаар баталж буй чухал олдвор юм.

Мин улсын үед хамаарагдах буюу хоёрдугаар тамга нь Шин Жоу-гийн Жун Түн-гийн харуулын Дунд Мянганы газар дахь Зуутын тамга он цагийн хувьд Юн ли-гийн тэргүүн он буюу 1403 он болох бөгөөд дээрх нэгжүүдийг шинэчлэн нэгж бүр 1000 өрхтэй дотроо 100 өрх тэргүүлсэн даргач нар тус бүр тамгатай байжээ.

Түүхэн сурвалжийн мэдээг шүүрдэн үзвэл 1414 онд Мин улсын хаан Ойрадын Дэлбэг,

Махмуд, Тайпин, Батболд нарыг дайлаар мордсон байдаг. Тус довтолгооны үеэр замаар аялан явсан Мингийн цэргийн эрхтний тамга байж болох юм хэмээн үзэж байна. Яг сурвалжид хааны цэргийн анги нэгтгэл Сүхбаатар аймгийн Сөдөтийн цагаан чулуугаар орж ирээд Хэрлэнгийн гүүр хүрээд буцсан мэт боловч [Ундрах 2020: 107-125] хөнгөн морьт цэрэг нь Монгол нутгийн баруун болон төвийн бүсээр довтолж явсан байж болох эсвээс хааны ахлан явсан цэргийн анги нэгтгэлээс өөр баруун замын анги нэгтгэл нь Онги гол даган орж ирсэн нь сурвалжид тэмдэглэгдсэнгүй байх боломжтой юм. Тиймээс Онги голын баруун эрэг Шаазан толгойн хотод Мингийн цэрэг хүрсэн нь баруун замын цэрэг нэвтэрч өргөн замаар Монгол руу довтолж байсан бололтой хэмээн үзэхээр байна.

Өвөрхангай аймгийн Богд суманд орших Шаазан толгойн эртний хотын туриас илэрсэн тус тамганууд нь ямартай ч тус хот Монголын эзэнт гүрэн тэр дундаа Юань улсын үед нэгэн томоохон төвлөрөл, Мин улсын үед түүрүү үед монгол нутаг руу дайлаар ирж байсан замуудын нэг болохыг нотлон харуулж байна.

Ном зүй

Бат-Эрдэнэ 2012 – Бат-Эрдэнэ Б. Хоёр хүрэл тамга. Музейн мэдээлэл. УБ, 2012. №06.

Пэрлээ 2001 – Пэрлээ Х. Монголын тамга зүйн асуудалд. Академич Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүлэлүүд. УБ, 2001.

Ундрах 2020 – Ундрах Д. орч. Нанхиад сурвалж дахь Монголын түүхэнд холбогдох ойлбор. УБ, 2020.


Farquhar 1990 – David M Farquhar. The Government of China under Mongolian Rule. A Reference guide. Münchener Ostasiatischer Studien. Band 53. Stuttgart. 1990.

Cleaves 1952 – Francis Woodman Cleaves. The Sino-Mongolian inscription of 1346. HJAS, v-XV, 1952.


元史 1976 – 元史. 卷五十八. 志第十. 地理一. 北京1976

张廷玉 1995 – 张廷玉. 明史(卷40) 北京:中华书局, 1995

韦占彬 2001 – 韦占彬. 兴州五卫与兴州五屯卫考辨. 石家庄师范专科学校学报. 2001



Нэгдүгээр тамга-Юань улсын үеийн тамга



Хоёрдугаар тамга-Мин улсын үеийн тамга

С.Хүрэлсүх¹✉

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Эртний нүүдэлчдийн ташууртай холбогдох олдворууд

Товчлол. Нүүдэлчид нэн эрт цагаас адууг уналга эдэлгээнд хэрэглэх явцдаа хэрэглээний онцлогт тохирсон олон төрлийн тоног хэрэгслийг бүтээн бий болгож, хөгжүүлэн уламжилсаар иржээ. Тэдгээр бүрдэл хэсгийн нэг нь ташуур юм. Ташуурын ишийг ширхэг нягт модоор, сагалдарга болон зангиаг сураар хийдэг уламжлалтай. Археологийн судалгаагаар эртний чулуун дарааст булшнаас ташууртай хамааралтай олдвор олоод байх нөхцөл тун бага ч нүүдэлчдийн өөр нэг оршуулгын өвөрмөц хэлбэр болох хадны оршуулгаас ташуурын мод илэрсэн хэд хэдэн тохиолдол байдаг. Эдгээр олдворт тулгуурлан адууны тоног хэрэгслийн нэг ташуурын талаар өгүүллээ.

Түлхүүр үг: Эртний нүүдэлчдийн ташуур, дундад зууны үед ташуурыг уран зургийн дурсгалд дүрсэлсэн нь, ташууртай холбогдох зарим зан үйл.

S.Khurelsukh¹✉

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

A Horse whip found an Ancient Nomadic Burials

Summary. This is article ancient nomadic whip. From time immemorial, nomads have used and developed a variety of equipment to suit the specifics of their use of horses for riding. One of them is a whip. The whip is traditionally made of solid wood with a strap and a tie. Archaeological excavations have shown that whip-related artifacts have been found in ancient tombs, but there have been a number of cases where whip trees have been found in rock burials, a unique form of nomadic burial. Based on these findings, a whip, a type of horse equipment, is described. According to the materials the ancient whip tree was found in 1 stone tomb from the Xiongnu period, 1 from the related rock burials in the Ancient Turkic period, 4 from the rock burials in the Great Khitan state, 3 from the Mongols period rock burials, and a total of 9 items were artifacts.

Keywords: *The whip of the ancient nomads, The whips found in rock burials*

Удиртгал

Нүүдэлчдийн бий болгосон мал аж ахуйн соёл тэр дундаа адууны уналга эдэлгээтэй холбогдсон тоног хэрэгсэл хэдэн мянган жилийн турш хэрэглээнд байж, улам боловсронгуй болсоор эдүгээг хүрсэн бөгөөд адууг эртнээс монголчууд өдөр тутмын ахуйгаас эхлээд ав хоморго, аян дайн, нүүдэл суудал, уналга ачилга, өртөөний алба зэрэг аль болох хурдан түргэн явдалд өргөн ашигласаар ирсэн нь тэдний амьдралын салшгүй нэгэн хэсэг болж, адууны арвин баялаг өв соёл буюу ногт, хазаар, эмээл, тохом, хударга, хөмөлдрөг, дөрөө, ташуур, чөдөр зэргийг бүтээн бий болгожээ.

Энэхүү баялаг өв соёлыг илтгэх олдворууд булш, оршуулгын дурсгалд урт удаан хугацаанд хадгалагдсан эмээлийн мод, дөрөө, хазаар зэргийг судлаачид түлхүү авч үзэн тодорхойлсон нь тохиолдох бөгөөд ташуурыг зөвхөн нэр дурдах төдийгөөр судалгааг нь орхигдуулж иржээ хэмээн үзэж болно. Энэ нь нэг талаар аргагүй шалтгаантай. Учир нь “органик” гаралтай материал буюу мод, сураар хийсэн ташуур нь хөрсөнд хэдэн зуун, мянган жилээр удаан хугацаанд хадгалагдан үлдэх боломжгүй тул булшнаас тэр бүр илэрч олдоод байх бололцоо багатай. Нөгөө талаар хөрсөнд үйлдсэн булшны эд өлгийн зүйлс нь олон жилийн халалт, хөрөлт, чийг зэрэг байгалийн нөлөөнд багагүй автдаг тул модны мөчрөөр хийсэн ташуур дийлэнхдээ ялзарч үлдэж хоцордоггүй. Тиймээс онцгой ховор тохиолдолд ташуурт хамаарах үлдэгдэл төдий олдворыг судлаачид ялган таниад, баримтжуулан тодорхойлно гэдэг бас их анхаарал, туршлага шаардсан ажил юм.

Харин хадны оршуулгын дурсгалын өвөрмөц орчин нөхцөлд ямар нэгэн олдворууд тэр дундаа мод, мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, нэхмэл бөс, төмөрлөг материалаар хийсэн эд өлгийн зүйлс байгалийн нөлөө бүхий өгөршилд харьцангуй бага өртөж, маш сайн хадгалагддаг онцлогтой. Тиймээс хадны оршуулгын хэд хэдэн дурсгалаас ташуурын мод илэрсэн бөгөөд энэ удаа археологийн биет олдворт тулгуурлан эртний нүүдэлчдийн агт морины нэгэн хэрэгсэл болох ташуурын талаар тусгайлан өгүүлэхийг зорилоо.

Археологийн олдвор

Эртний нүүдэлчдийн булш оршуулгын дурсгалаас агт морины тоног хэрэгсэл тэр дундаа хазаар, эмээл, дөрөө, хөмөлдрөг, хударга ихэвчлэн илэрч гардаг хэдий ч морь унахад эдгээрийн адил багагүй үүрэгтэй ташуурын мод илэрсэн нь их цөөхөн. Өмнө дурдсанчлан ташуурыг модны мөчир, нарийн сур ашиглан хийдэг тул хөрсөнд удаан хадгалагдах боломж ихээхэн хязгаарлагдмал юм. Гэсэн хэдий ч монголчуудын өндөр өвөг хүннүчүүдийн чулуун дарааст булшнаас илэрсэн цор ганц гэж үзэж

болох тохиолдол бий. Тухайлбал, Ховд аймгийн Булган сумын нутаг Авын Хөх уулын хүннүгийн 20-р булшны малтлагаар 190 см гүнд оршуулга илэрсэн ба хүний ясны хөл талд хоёр шилбэний завсар ташуурын модыг тавьсан [Төрбат нар 2015: 305] байсан ба олдворын тодорхойлолт хэсэгт “ташуурын мод 11 хэсэг болсон ба хадгалалт муу. Хоорондоо эвээрээ нийлнэ. Нэг үзүүрээс 1 см орчим жижиг булцуутай ба хөндлөн гаргасан нүхтэй. Нүхний голч 0,2 см. Эвлүүлсэн үеийн урт 38,3 см, голч 0,9 см” (зураг 1а) хэмээн дурджээ [Төрбат нар 2015: 307].

Эртний нүүдэлчдийн оршуулгын өөр нэгэн хэлбэр болох хадны оршуулга нь нар үзэхгүй, чийг орохгүй хуурай, сэрүүн нөхцөлтэй байж агаарын солилцоог нэгэн зэрэг хангаж өгдөг байгалийн өгөгдөлтэй гэж ойлгож болно. Хадгалалтын нэн таатай ийм орчинд маш сайн хадгалагдсан ташуурын мод хэд хэдэн оршуулгаас илэрчээ. Тухайлбал, Жаргалант Хайрханы оршуулгаас олдсон “ташуурыг модны мөчир бололтой, холтослоогүй урт нарийн модоор хийсэн. Модны хоёр үзүүрийн төгсгөлийг мөлийлгөн зассан. Бариул хэсэгт нэвт цоолж гаргасан нүх буй нь сагалдарга уяхад зориулсан. Сурын үлдэгдэл хадгалагдаж үлдээгүй. Энэхүү ташуур гурван хэсэг болж хугарсан байх боловч эвээр нь нийлүүлэхэд бүтэн болно. Ташуурын урт 100,6 см, өргөн 1,1 см хэмжээтэй” (зураг 1б) [Батсүх нар 2014: 236].

Арцат Дэлийн хадны оршуулгаас “нарийн үзүүртээ хугархай, засаж боловсруулаагүй модны мөчрөөр хийсэн ташуур илэрсэн. Нэг үзүүртээ сагалдаргын сур оруулах амсрыг нь томгосон нүхтэй. Бариул хэсэгтээ давхар ороосон сурын үлдэгдэлтэй. Ташуурын урт 53,5 см урттай” (зураг 1в) [Эрдэнэбат нар 2005: 85]. Дугуй Цахирын хадны оршуулгаас “бургасны мөчрөөр хийсэн ташуурын үлдэгдэл илэрсэн. Нэг үзүүр бяцарч гэмтсэн. Нөгөө үзүүр буюу бариулын хэсгийн төгсгөлийг гурвалжлан засаж, сагалдаргын оосор сүвлэн оруулах нэвт нүх гаргасан нь 0,6 см голчтой. Ташуурын урт 60,2 см, бүдүүн нь 1,5 см” (зураг 1г) [Эрдэнэбат нар 2010: 35].

Үзүүр Гялангийн оршуулгаас илэрсэн “ташуурыг бургас модоор хийсэн. Бариул хэсэгтээ сагалдаргын нүхтэй, гол хэсэгтээ 2-3 үе ороосон нарийн сурын үлдэгдэлтэй. Урт 91 см хэмжээтэй” (зураг 1д) [Энхтуяа 2017: 47]. Чонот уулын оршуулгаас илэрсэн “ташуурыг сухай модоор хийсэн. Урт 36,8 см, өргөн 0,94 см. Бариул болон үзүүр хэсгийг зорьж тэгшилсэн. Бариул хэсэгт сагалдаргын сур сүвлэх нэвт нүх гаргасан бөгөөд уг нүхэнд хатсан сурын үлдэгдэлтэй” (зураг 1е) [Turbat et al. 2012: 282]. Хагтын оршуулгаас илэрсэн “ташуурыг харавтар өнгийн нарийн бургасаар хийсэн. Хоёр үзүүрийг зорьж дугуйлан

ирмэгийг дарсан. Бариул хэсэгт сагалдаргын нүх гаргасан. Урт 30,8 см, голч 1,7 см хэмжээтэй” (зураг 1ө) [Амартүвшин нар 2020: 121].

Цагаан хадны оршуулгаас илэрсэн “ташуурын мод нь далийж мурийсан зүйлгүй шулуун ба 38,8 см урт, 1,8 см өргөнтэй. Хоёр үзүүрийг ирмэглэж зассан. Бариул хэсэгт сагалдаргын нүх гаргасан бөгөөд эндээ сурын үлдэгдэлтэй” (зураг 1з) [Ahrens et al. 2015: 96].

Өндөр Хүрэний хадны оршуулгаас илэрсэн ташуур [몽골의 문화 유산 2010: 77] нь бариул хэсэгтээ сагалдаргын сур оосорлох нүхгүй, харин модны үзүүр хэсэгт “булцуу” гарган түүнийхээ дор залгуулан ховил гаргасан. Энэ тээглүүр бүхий нарийн ховил хэсэгт сагалдаргын сурыг бэхэлж уядаг байжээ. Уг ташуурын модонд сагалдарга болон сурыг холбож уясан нь тэр чигтээ зангилаатайгаа үлджээ (зураг 8а). Урт 33 см, өргөн 1,2 см, сагалдаргын сурыг торгоох булцуу 2 см өргөнтэй, нарийн хүзүү 0,8 см хэмжээтэй (зураг 1ж).

Эдгээр археологийн олдвороос үзэхэд хүннүгийн үеийн чулуун дарааст булшнаас ташуурын мод илэрсэн нь тун ховор тохиолдол юм. Ташуурын иш буюу нарийн урт мод хоёр мянган жилийн хугацаанд хадгалагдан өнөөг хүрсэн нь Алтайн нурууны өндөрт орших цэвдэгтэй бүс нутаг археологийн олон дурсгалыг маш гайхалтай хадгалагдаж үлдэх нөхцөл болж байжээ. Бусад ташуурын мод хадны оршуулгаас илэрсэн бөгөөд ташуурын ишинд сагалдаргын нүх гаргасан байх ба зарим тохиолдолд сагалдаргын сурын үлдэгдэлтэй, зарим нь суртайгаа илэрчээ. Эдгээр 9 олдвороос гадна ташууртай холбогдох зарим лавлах хэрэглэгдэхүүн бий.

Манай улсын нутгаас илэрсэн дээрх олдворуудаас гадна БНХАУ-ын баруун хойд бүс нутаг болох Шинжааны хэт хуурай, бараг бороо ордоггүй элсэн цөл бүхий Турфан хотын орчимд байх Янхай-I оршуулгын газарт 218 булш, Янхай- II оршуулгын газарт 223 булш

малтан шинжилсэн байх ба зарим булшнаас нь тун сайн хадгалалттай цөөн хэдэн ташуур болон ташуурын мод илэрчээ (зураг 3а-и) [新疆洋海墓地 2019: 30, 38, 45, 97, 115, 238, 280, 366]. Эдгээр олдвор нь хэдэн мянган жилийн хугацаанд тун сайн хадгалалттай байгаа нь чийггүй хуурай уур амьсгалтай бүс нутгийн элсэн манханд тавьсан оршуулга учраас булшинд дагалдуулсан эд өлгийн зүйлс нь байгалийн хүчин зүйл бүхий өгөршилд авталгүй тэр хэвээрээ хадгалагджээ. Янхай-I оршуулгын газрын булшнуудаас илэрсэн ташуурын модыг манай улсын нутгаас илэрсэн ташуурын олдворуудтай харьцуулан авч үзэхэд ерөнхийдөө ойролцоо хэлбэр хэмжээтэй байна. Тухайлбал, 11-р булшнаас илэрсэн ташуурын ишний урт 31,8 см урт, 1,3 см өргөнтэй [新疆洋海墓地 2019: 29], сагалдаргын сурыг мөн адил ишний үзүүр хэсэгт нүх гарган тогтоож, нарийн уртавтар сур унжуулжээ (зураг 3а).

Энэ бүс нутаг цөлөрхөг элсэн манхан ихтэй учир магадгүй адуунаас гадна тэмээ зэрэг бусад амьтдын уналга эдэлгээнд доорх ташууруудыг ашиглаж байсан байх. Учир нь Янхайн соёлыг үлдээгчдийн зарим хэсэг нь хагас нүүдэлчид бөгөөд булшны малтлагын тайлангаас үзэхэд ташуурын олдвортой нүүдэлчдийн гол илэрхийлэл болох эмээл хамт илэрсэн тохиолдол тэмдэглэгдээгүй байдаг.

Уран зургийн дурсгалд ташуурыг дүрсэлсэн нь


Бунхны ханын зурагт. Хятаны бунханд оршуулгад бусад цаг үеийн булшны адил талийгаачийн эдэлж хэрэглэж байсан хувцас өмсгөл, гоёл чимэглэл, сав суулгын зүйлсийг дагалдуулан тавьдаг ч хамгийн сонирхолтой нь бунхны хананд баялаг агуулга бүхий өнгө ялган будсан зураг зурсан байдаг ажээ. Ханын зурагт талийгаачийн зэрэг зиндаа, амьд ахуйдаа ямар үйл хэрэг эрхэлж байсан, нутаглаж байсан газар ус, ахуй амьдрал, ан ав, аялал зугаалга, хувцас

Хүснэгт 1. Ташуурын мод илэрсэн оршуулгуудын олдсон газар, холбогдох он цаг


№	Дурсгал	Олдсон газар	Холбогдох он цаг (C14)
1	Авын Хөх уулын 20-р булш	Ховд, Булган	НТӨ 43 – НТ 89 он
2	Жаргалант Хайрхан	Ховд, Манхан	590-670 он
3	Арцаг Дэл	Баянхонгор, Бөмбөгөр	950-иад он
4	Дугуй Цахир	Баянхонгор, Баянцагаан	992-1146 он
5	Үзүүр Гялан	Ховд, Мөнххайрхан	X зуун
6	Чонот уул	Ховд, Булган	1020-1210 он
7	Хагт	Баян-Өлгий, Алтанцөгц	1271-1290 он
8	Цагаан хад	Өвөрхангай, Богд	1300-1370 он
9	Өндөр Хүрэн	Говь-Алтай, Чандмань	1330-1410 он

Хүснэгт 2. Ташуурт хамаарах олдворын харьцуулалт, ангилал

№	Олдвор	Модны төрөл	Ташуурын урт	Сагалдаргын нүхтэй эсэх	Ангилал
1	Авын Хөх уулын 20-р булш	-	38,3 см	байгаа	дундаж
2	Жаргалант Хайрхан	бургас	100,6 см	байгаа	урт
3	Арцат Дэл	яргай	53,5 см	байгаа	урт
4	Дугуй Цахир	бургас	60,2 см	байгаа	урт
5	Үзүүр Гялан	бургас	91 см	байгаа	урт
6	Чонот уул	сухай	36,8 см	байгаа	дундаж
7	Хагт	бургас	30,8 см	байгаа	богино
8	Цагаан хад	сухай?	38,8 см	байгаа	дундаж
9	Өндөр Хүрэн	яргай	33 см	байхгүй	дундаж



Зураг 1. а. Авын Хөх уулын хүннү булш, б. Жаргалант хайрхан, в. Арцат дэл, г. Дугуй Цахир, д. Үзүүр Гялан, е. Чонот уул, ё. Хагт, з. Цагаан хад, ж. Өндөр Хүрэн зэрэг оришуулгаас илэрсэн ташуурын моднууд



Зураг 2. Ташуурын моднуудын бариул хэсгийн үзүүрт сагалдаргын сур сүвлэх нүхийг гаргасан ба зарим нь сурын үлдэгдэлтэйгээ. Өндөр Хүрэний оришуулгаас илэрсэн ташуурын модонд “булцуу” гарган нарийн хүзүү хэсэгт нь сагалдаргын сурыг уяж байсан ажээ.

өмсгөл, хоол хүнс, тоглоом наадгай зэрэг олон сэдвийн хүрээнд ердийн нэг бодит дүрслэл байхаас гадна маш өргөн гүн агуулгатай зургийн дүрслэл ч байдаг. Өөрөөр хэлбэл зарим бичгийн сурвалжид тэмдэглэсэн мэдээ, баримтыг нүдээрээ харж мэдэх боломж нээгддэг. Тиймээс түүхийн дутмаг талыг нөхвөрлөх, сурвалжийн мэдээг нягтлан үзэх, бичгээр тэмдэглэгдэж үлдээгүй

зарим зүйлийг тодорхой үйл явдалтайгаар зургаар харуулсан чухал эх сурвалж болдог ажээ [Баянтал 2021: 106].

Нүүдэлчидтэй гарал угсаа нэгтэй хятанчууд адууг уналга эдэлгээнд өргөн хэрэглэж байсныг бунхны ханын зургаас харж болох бөгөөд эзнээ ан ав, аян жинд явах үед нь унаа морийг нь хазаар, эмээл, тохом, дөрөө, ташуур, хөмөлдөрөг, хударга